



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 8/224

Улаанбаатар хот

Г Аргачлал батлах тухай


Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4, Захиргааны зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-д дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлийг үнэлэх аргачлал”-ыг хавсралтаар баталж, 2018 оны 09 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдсүгэй.
2. Аргачлалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инноваци, гадаад харилцаа хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), бүрэлдэхүүн сургуулийн салбарын эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР



МУИС-Д ДОТООДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Аргачлалын зорилго

1.1.1. МУИС-д дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлийг бүртгэхэд тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтыг гаргахад энэхүү аргачлалын зорилго оршино. Жагсаалтыг профессор, багшийн Б цагийн үнэлгээ, магистрант, докторантын судалгааны ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглана.

1.2. Нэр томъёоны тодорхойлолт. Энэхүү аргачлалд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.2.1. “Эрдэм шинжилгээний сэтгүүл” (цаашид сэтгүүл гэх)- тухайн шинжлэх ухааны чиглэл эсхүл салбар дундын шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилгоор идэвхитэй судлаачдын гүйцэтгэсэн шинэ судалгааны үр дүн бүхий өгүүллийг хянан магадалж, тогтмол хугацаанд хэвлэдэг сэтгүүл.

1.2.2. “Редакцийн зөвлөл”- сэтгүүлд нийтлүүлэх өгүүллийн эхийг хүлээн авах, хянан магадлагааг зохион байгуулах, зохиогчтой харилцах, чанартай агуулгыг хэвлэн нийтлүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй тухайн шинжлэх ухааны чиглэлд мэргэшсэн, хүлээн зөвшөөрөгдсөн, судалгааны өндөр гүйцэтгэл (олон улсын сэтгүүлд бүтээлээ хэвлүүлсэн, эшлэгдсэн байдал) -тэй эрдэмтдээс бүрэлдсэн зөвлөл. Редакцийн зөвлөлийн гишүүд шинжлэх ухааны өндөр чанарын өгүүллийг хянан магадлан шалгаруулж сэтгүүлдээ хэвлүүлэх, ерөнхий редакторт туслах үндсэн үүрэгтэй.

1.2.3. “Хянан магадлагаа”- редакцийн зөвлөлөөс өгүүлэл бичигдсэн тухайн шинжлэх ухааны чиглэлээр хөндлөнгийн шинжээч урьж ажиллуулан бүтээлийн агуулгын чанарын өндөр түвшний үнэлгээ хийлгэх үйл явц.

1.2.4. “Эрдэм шинжилгээний өгүүлэл” (цаашид өгүүлэл гэх)- тухайн шинжлэх ухааны чиглэлийг ирээдүйд хөгжүүлэх зорилгоор гүйцэтгэсэн анхдагч судалгааны үр дүнг хянан магадлан тогтмол хэвлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн бүтээл.

1.2.5. “Олон улсын стандартын сериал дугаар”(цаашид ОУССД гэх)-сэтгүүлийн давтагдашгүй найман оронтой олон улсын стандарт сериал дугаар (ISSN олон улсын төв).

ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛД ҮНЭЛГЭЭ ХИЙХ

2.1. Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл үнэлгээ хийгдсэн сэтгүүлийн жагсаалтыг жил бүр шинэчилж, 5 дугаар сарын 1-ний дотор баталгаажуулна (дараа жилд мөрдөх сэтгүүлийн жагсаалтыг гаргана).

2.2. Авбал зохих нийт онооны 80% ба түүнээс дээш үнэлгээ авсан сэтгүүлийг жагсаалтад оруулна.

2.3. Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл МУИС-д бүртгэлтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн үнэлгээний тайлан болон шалгуур үзүүлэлттэй холбоотой саналыг жил бүрийн 05 дугаар сарын 10-ны дотор Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс (ЭШИХ)-т хүргүүлнэ.

2.4. Сэтгүүлийн шалгуур үзүүлэлтийг МУИС-ийн Эрдмийн зөвлөл хэлэлцэж батална.

ГУРАВ. СЭТГҮҮЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Сэтгүүлийн нэр, агуулга

3.1.1. Сэтгүүлийн нэр, бодлого, шинжлэх ухааны чиглэл, өгүүллийн агуулгын хүрээ тодорхой байна.

3.2. Эрхлэн гаргадаг байгууллага

3.2.1. Магадлан итгэмжлэгдсэн төрийн өмчийн их, дээд сургууль, Монгол Улсын Шинжлэх ухааны академи (ШУА)-ийн хүрээлэн, бусад судалгааны хүрээлэн болон мэргэжлийн нийгэмлэг, холбоод байна.

3.3. Редакцийн зөвлөл

3.3.1. Редакцийн зөвлөл нь эрхлэгч, техникийн редактор, бусад нөөц хянан магадлагчидтай байна. Техник редактораас бусад зөвлөлийн гишүүд докторын зэрэгтэй байх ба тухайн салбартаа судалгааны өндөр гүйцэтгэлтэй, нэр хүндтэй эрдэмтэд байна.

3.4. Хянан магадлагаа

3.4.1. Өгүүллийн бичлэг, судалгааны арга зүй, үр дүн, шинэлэг тал, ач холбогдол, дүгнэлт, шинжлэх ухаанч логик уялдаатай байдлын талаар зөв үнэлэлт, дүгнэлт хийх, тухайн нарийн мэргэжлийн чиглэлээр судалгаа хийдэг, мэргэжлийн хянан магадлагч нараар уншуулж хэвлэх эсэх талаар дүгнэлт гаргуулдаг байна.

3.5. Англи хураангуй

3.5.1. Өгүүллийн хураангуйг англи хэл дээр бичсэн байна. Өгүүлэл англиас өөр хэлээр бичигдсэн тохиолдолд 2 хураангуй (тухайн өгүүлэл бичигдсэн хэлээр болон англи хэлээр) байна. Англи хэлээр бичигдсэн хураангуйн өмнө өгүүллийн нэр, зохиогчид буюу хувь нэмэр оруулсан судлаачдын нэр, тэдгээрийн харьяалал, хураангуйн ард түлхүүр үгсийг бичнэ.


3.6. Тогтмолжсон байдал

3.6.1. Сэтгүүл төлөвлөгдсөн хугацаандаа хэвлэгддэг байна.

3.6.2. Сүүлийн 2 жилд 2 ба түүнээс дээш сэтгүүлийн дугаар хэвлэгдсэн байна.

3.7. Ёс зүйн баталгаа

3.7.1. Сэтгүүл цахим хуудас эсхүл хэвлэлийн эхийн бэлтгэх шаардлагадаа "хэвлэлийн болон судалгааны ажлын ёс зүйн нийтлэг шаардлагыг хангасан (бусдын бүтээл, бүтээлийн хэсэг болон санаа хуулбарлаагүй, анхдагч үр дүнтэй, бүтээл ашиг сонирхлын зөрчилгүй, үнэн зөв хийгдсэн) бүтээлийг хэвлэнэ" гэсэн утга агуулга бүхий мэдэгдэл оруулсан байна.



3.8. Олон улсын стандартын сериал (ОУССД) ISSN дугаартай байх

3.8.1. Хэвлэмэл сэтгүүл Print ISSN буюу p-ISSN ОУССД-ын хувилбартай байна.

3.8.2. Цахим сэтгүүл electronic ISSN буюу e-ISSN ОУССД-ын хувилбартай байна.

3.9. Сэтгүүлийн талаарх мэдээлэл

3.9.1. Сэтгүүл цахим хуудастай буюу цахим хайлтаар илэрдэг, хэвлэн нийтлүүлсэн дугааруудын мэдээлэл хайлт хийх боломжтой эсхүл олон улсын бүртгэлийн системд бүртгэгдсэн ба индекслэгдсэн байна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Сэтгүүлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо

4.1.1. Сэтгүүлийн хэвлэлийн бодлогын үзүүлэлт нийт 30% байна. Үүнд:

4.1.1.1. Сэтгүүл тодорхой шинжлэх ухааны чиглэлд төвлөрсөн (5%);

4.1.1.2. Хянан магадлагчдын харьяаллын тархалт өргөн (5%) байна. Үүнд:

а) олон улсын ба өөр өөр тивүүдээс-5 %

б) олон улсын ба нэг тивээс-3 %

в) үндэсний ба өөр өөр хүрээлэнгүүдээс-2 %

д) үндэсний ба нэг хүрээлэн буюу сургуулиас-1 %.

4.1.1.3. Зохиогчийн харьяаллын тархалт өргөн (5%) байна. Үүнд:

а) олон улсын ба өөр өөр тивүүдээс-5 %

б) олон улсын ба нэг тивээс-3 %

в) үндэсний ба өөр өөр хүрээлэнгүүдээс-2 %

д) үндэсний ба нэг хүрээлэн буюу сургуулиас-1%.

4.1.1.4. Сэтгүүлийн өгүүллийн хураангуйг англи хэлээр бичсэн байна (5%);

4.1.1.5. Өгүүллийн бичигдсэн хэлээс хамааралгүй эшлэлийг англи хэлээр орчуулж бичсэн байна (5%);

4.1.1.6. Сэтгүүл хянан магадлагааны журамтай байна (5%).

4.2. Ёс зүйн баталгааны үзүүлэлт нийт 10% байна. Үүнд:

4.2.1. Бусдын бүтээл, өгүүллийн хэсэг болон санаа хуулбарлаагүй байна (4%);


4.2.2. Өгүүлэлд анхдагч үр дүн гэсэн тэмдэглэл байна (3%);

4.2.3. Өгүүлэл ашиг сонирхлын зөрчилгүй, үнэн зөв бичигдсэн байна (3%);

4.3. Өгүүллийн агуулга, чанарын үзүүлэлт нийт 30% байна. Үүнд:

4.3.1. Бичсэн хэлний үзүүлэлт 10 % байна. Үүнд:

- а) англи (10 %)
- б) англи ба монгол (5 %)
- в) бусад гадаад хэл ба монгол холимог (3%)
- г) дан монгол (1 %);



4.3.2.Хураангуйн ойлгомжтой уншигдах байдал (5%);

4.3.3.Сэтгүүлийн зорилго, хамрах хүрээтэй нийцэж байгаа байдал (5%);

4.3.4.Ойлгомжтой уншигдах байдал (хэлний болон дүрмийн талаас) (5%).

4.4. Сэтгүүлийн тогтмолжсон байдлын үзүүлэлт нийт 15% байна.

4.4.1.Сэтгүүл төлөвлөгдсөн хугацаанаасаа хоцролгүй хэвлэгддэг байна. Үүнд:

- а) хугацаандаа хэвлэгддэг бол (15%);
- б) нэг гаралт хойшилсон бол (10 %);
- в) 2-3 гаралт хойшилсон бол (5 %) буюу
- г) 4-өөс дээш гаралт хойшилсон бол (1 %).

4.5. Сэтгүүлийн талаарх мэдээллийн үзүүлэлт нийт 15% байна. Үүнд:

- а) сэтгүүлийн цахим хуудас англи эсхүл англи болон монгол хэл дээр байна (3%);
- б) цахим хуудсын чанар (3%);
- в) гол мэдээллийн баазуудад хамрагдсан байна (3%);
- г) p-ISSN, e-ISSN бүртгэлийн дугаар байна (3%);
- д) бүх бүтээл гарчиг, түлхүүр үг, зохиогч, хураангуй зэрэг бусад мэдээллээр хайлт хийх боломжтой онлайн байна (3%).

4.6. Үнэлгээг бууруулах үзүүлэлтүүд нийт 20% байна. Үүнд:

4.6.1. Редакцийн зөвлөлийн гишүүн ба зохиогчид ижил байгууллагад харьяалагддаг (-3%);

4.6.2.Бүтээлийн хулгай (бусдын бүтээл, бүтээлийн хэсэг болон санаа хуулбарласан) (-5%);

4.6.3.Зөв бичгийн дүрмийн алдаатай (-4%);

4.6.4.Зургийн чанар муу (-2%);

4.6.5.Өгүүллүүдийн чанар хоорондоо эрс ялгаатай (-3%);

4.6.6. Цахим хуудасны чанар муу (ажилладаггүй, мэдээлэл бүрэн бус) (-3%).

--- оОо ---

